



Оюу Толгой компанийн ажилчид төрийн хишиг хүртэв

www.ot.mn

Managed by

RioTinto

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2014 оны гуравдугаар сарын 12-ны өдрийн 29 дүгээр зарлигаар Оюу Толгой компанийн нөөцийн ерөнхий геологич Т.Отгонбаярыг “Алтан гадас” одонгоор, жолооч Ч.Төмөрбаатар, биологийн төрөл зүйлийн судалгаа шинжилгээний ерөнхий зөвлөх С.Дорждэрэм, ил уурхайн төлөвлөлтийн ахлах инженер Г.Идэр, үйлчлэгч Б.Одгэрэл, ахлах мужаан Б.Баяраа, баяжмал ба эрх зүйн менежер М.Ганболд, мэдээлэл

технологийн үйлчилгээний ахлах ажилтан Н.Нанжид, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Т.Баасанцэрэн нарыг Хөдөлмөрийн хүндэт медалиар шагнажээ. УУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Р.Жигжид гуравдугаар сарын 19-ний өдөр тэдэнд шагнал гардуулж баяр хүргэв.

Оюу Толгой компанийн ерөнхийлөгч бөгөөд гүйцэтгэх ерөнхий захирал Крэйг Киннел

төрийн дээд одон, медалиар шагнуулсан ажилтнуудаа хүлээн авч баяр хүргэхдээ “төрийн нэр хүндтэй өндөр шагнал хүртсэн та бүхэндээ компанийн удирдлагын нэрийн өмнөөс болон хувиасаа халуун баяр хүргэе. Улс эх орондоо, Оюу Толгойн бүтээн байгуулалтад та бүхний оруулсан хөдөлмөрийг тань төр өндрөөр үнэлж шагналаа хүртээлээ. Би та бүхнээрээ үнэхээр их бахархаж байна” гэлээ.



Т.ОТГОНБАЯР

2002 оноос Оюу Толгой компанид ажиллаж байгаа. Геологи шинжилгээний шинэ арга аргачлал нэвтрүүлэх, төслийн хүрээнд хийсэн өрмийн дээжний чанарын хяналтын ажлыг удирдан зохион байгуулж хэрэгжүүлэх, Оюу Толгой ордын нөөцийг тогтооход үнэн бодит геологийн мэдээллээр хангахад дорвитой хувь нэмэр оруулсан юм.



Б.ОДГЭРЭЛ

Оюу Толгой компанийг үүсгэн байгуулагдахаас одоог хүртэл ажиллаж байгаа, залуу үеийг халамжлан хүмүүжүүлэгч ахмад ажилтан юм.



Н.НАНЖИД

Компанийн тогтвортой үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлж, шинэ систем, техник технологийн шинэчлэл, сүлжээний үйл ажиллагаанд шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд хувь нэмрээ оруулжээ.



Г.ИДЭР

Оюу Толгой компанид арав гаруй жил ажиллаж байна. Ил уурхайн дотоод овоолготой тээвэртэй ашиглалтын системийг анх удаа нэвтрүүлж, ил уурхайн тээвэр, хөрс хуулалт, байгаль орчны нөхөн сэргээлтийг нэмэгдүүлж, зардал хэмнэсэн технологи нэвтрүүлсэн юм.



М.ГАНБОЛД

Баяжуулах үйлдвэрийн технологийг жигдрүүлэх, үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлтүүдийг дээшлүүлэх, баяжуулалтын багийг удирдахад амжилт гаргасан юм.



Б.БАЯРАА

Оюу Толгой компанид 2003 оноос, улсад 40 гаруй жил ажиллаж, хариуцсан ажлаа чадамгай гүйцэтгэдэг, үлгэр жишээч, хамт олны дунд нэр хүндтэй ажилтан юм.



Ч.ТӨМӨРБААТАР

Оюу Толгой компанид анхнаас нь ажиллаж байгаа, залуучуудад үлгэр дууриал үзүүлэгч ахмад ажилтан юм.



С.ДОРЖДЭРЭМ

Оюу Толгой компанийн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг олон улсын стандартын шаардлага хангасан өнөдөр түвшинд хүргэх, биологийн нөхөн сэргээлтийг говийн бүсэд зөв зохистой гүйцэтгэхэд шинэ арга технологи нэвтрүүлэхэд хувь нэмрээ оруулсан юм.